



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/162

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е” дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Казак үндэстний “Наурыз” баярыг тохиолдуулан аймаг, орон нутгийн хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд өөрийн сэтгэл зүрх, эрдэм мэдлэгээ дайчлан хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй хавсралтад дурдсан нэр бүхий (5) албан хаагчдын хөдөлмөр, зүтгэлийг өндрөөр үнэлж, аймгийн Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнахад 150, 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

84000001 0125
Zah A/162 Kh

Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 20-ны өдрийн
А/162 дугаар захирамжийн
хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДСАН АЛБАН ХААГЧДЫН НЭРС

Д/д	Овог, нэр	Эрхэлдэг ажил, албан тушаал
1	С. Болатбек	Буянт сумын Эрүүл мэндийн төвийн багийн эмч
2	Х.Мөлдир	Ховд сумын Эрүүл мэндийн төвийн хүний их эмч
3	Е. Нуржулдыз	Буянт сумын Эрүүл мэндийн төвийн сувилагч
4	Ж.Бигүль	Үенч сумын Эрүүл мэндийн төвийн сувилагч
5	Б.Мереке	Монгол Улсын Их Сургуулийн Баруун бүсийн сургууль

-оОо-